



Хэвлэлийн мэдээ  
2022 оны 4-р сарын 11

Холбоо барих  
9909-1557

**АмЧам Монголын санал дэмжигдэж  
“Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-д өөрчлөлт оруулахаар боллоо**

УЛААНБААТАР, Монгол Улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2022 оны 3-р сарын 10-ны өдөр “Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлууд” сэдвээр Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А. Ариунзаяатай уулзалт зохион байгуулсан билээ. Энэхүү уулзалтын үеэр хөндөгдсөн асуудлуудын нэг болох “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-д өөрчлөлт оруулахыг саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нааштайгаар хүлээн авч, 3 дугаар сарын 17-ны өдөр ХНХ-ын сайдын А/47 тоот тушаалаар энэхүү журмын 2.2 дахь хэсэгт шаардлагатай өөрчлөлтийг оруулсныг дуулгахад таатай байна. Ингэснээр цар тахлын энэхүү хүнд үед Монгол улсын ажил олгогч аж ахуйн нэгжүүд болон бизнесүүдийн хувьд үүсэх байсан их хэмжээний нэмэлт зардал болон санхүүгийн дарамтыг буурууллаа.

Тиймд АмЧам Монгол нь гишүүн байгууллагуудынхаа нэрийн өмнөөс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А. Ариунзаяа болон ХНХЯ-ны хамт олонд бидний саналыг хүлээн авч, Монгол Улсын хөдөлмөр эрхлэлт, цаашлаад бизнесийн орчинд таатай нөхцөл бүрдүүлэх ажилд дэмжлэг үзүүлсэн явдалд талархаж байгааг хүлээн авна уу.

Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулга, түүнийг дагалдан гарсан шинэ журмуудын хэрэгжилтэнд бид цаашид үргэлжлүүлэн анхаарч, ажил олгогчдын санал бодол, тулгарч буй бэрхшээлүүдийн талаар тууштай илэрхийлэн, Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжсэн ажил, хэлэлцүүлгүүдийг шат дараалан хийж, хамтран ажиллах болно.

**АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.



МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2022 оны 03 сарын 17-нд  
өдөр хүлээн авсан.

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/49


Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.2 дахь хэсгийн "... цалин хөлсөөр тооцно." гэсний дараа "Энэ тохиолдолд дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулахгүй байж болно. Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоноор нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулж болно." гэж нэмсүгэй.

2. Энэхүү тушаалыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

САЙД  ААРИУНЗАЯА



0-2022-03-03-00000000